

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/2/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.14 № 2/44

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.ЭНХТӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд шинээр “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-т 10,000.0 мянга, “Ногоон ажлын байр хөтөлбөр”-т 550,000.0 мянган төгрөг баталж, хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 стратеги зорилтыг хэрэгжүүлэх 94 арга хэмжээ, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2022 оны хөгжлийн

005020232

төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 97.9 хувьтай тайлагнасан ба дээд шатны байгууллагаас үнэлээгүй байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,567,454,397.00</u>	<u>2,057,657,056.00</u>
33	АВЛАГА	1,567,454,397.00	2,057,657,056.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,617,000.00	-
335	Бусад авлага	1,563,837,397.00	2,057,657,056.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,563,837,397.00	2,057,657,056.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,567,454,397.00</u>	<u>2,057,657,056.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,120,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,120,000.00
413	Өглөг	-	1,120,000.00
4136	Бусад өглөг	-	1,120,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,120,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,567,454,397.00</u>	<u>2,056,537,056.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,567,454,397.00	2,056,537,056.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,567,454,397.00	2,056,537,056.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,796,720,450.00	1,567,454,397.00
51220	Тайлант үеийн үр дүн	(229,266,053.00)	489,082,659.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,567,454,397.00</u>	<u>2,057,657,056.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

1	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	730,978,400.00	2,113,484,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,388,000.00	13,201,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,388,000.00	13,201,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,388,000.00	13,201,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,388,000.00	13,201,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	723,590,400.00	2,100,283,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,590,400.00	2,100,283,000.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	39,749,500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	683,840,900.00	2,100,283,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	960,244,453.00	1,624,401,641.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,244,453.00	1,624,401,641.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,297,650.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,297,650.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,297,650.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	915,946,803.00	1,624,401,641.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	631,303,281.00	1,095,153,851.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	631,303,281.00	1,095,153,851.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,643,522.00	529,247,790.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,643,522.00	529,247,790.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(229,266,053.00)	489,082,659.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	730,978,400.00	2,117,101,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,388,000.00	13,201,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,388,000.00	13,201,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,388,000.00	13,201,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,388,000.00	13,201,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	723,590,400.00	2,103,900,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	3,617,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,617,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,590,400.00	2,100,283,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	39,749,500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	683,840,900.00	2,100,283,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,012,313,153.00	2,526,401,641.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,313,153.00	2,526,401,641.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,297,650.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,548,150.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,548,150.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,749,500.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,724,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,025,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	968,015,503.00	2,526,401,641.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	679,754,981.00	1,997,153,851.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	679,754,981.00	1,997,153,851.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,617,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,617,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,643,522.00	529,247,790.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,643,522.00	529,247,790.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(281,334,753.00)</u>	<u>(409,300,341.00)</u>
14	Бусад эх үүсвэр	281,334,753.00	409,300,341.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	281,334,753.00	409,300,341.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>281,334,753.00</u>	<u>409,300,341.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,567,454,397.00	0.00	1,567,454,397.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,567,454,397.00	0.00	1,567,454,397.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,567,454,397.00	0.00	1,567,454,397.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,567,454,397.00	0.00	1,567,454,397.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,567,454,397.00	0.00	1,567,454,397.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	489,082,659.00	0.00	489,082,659.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,056,537,056.00	0.00	2,056,537,056.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,100,283,000.00	1,997,153,851.00	103,129,149.00	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,100,283,000.00	1,997,153,851.00	103,129,149.00	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,095,783,000.00	1,992,653,851.00	103,129,149.00	95.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,095,783,000.00	1,992,653,851.00	103,129,149.00	95.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,095,783,000.00	1,992,653,851.00	103,129,149.00	95.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,100,283,000.00	1,997,153,851.00	103,129,149.00	95.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,100,283,000.00	1,997,153,851.00	103,129,149.00	95.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,100,283,000.00	1,997,153,851.00	103,129,149.00	95.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,997,153,851.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,997,153,851.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,992,653,851.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,992,653,851.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,992,653,851.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,100,283,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,100,283,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,100,283,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг хэрэгжүүлэх" зорилгын дор "Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхийн зэрэгцээ Хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлого шийдвэртэй уялдуулж "Халамжаас-хөдөлмөрт" зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж, 902,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй 207 иргэнд үзүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 1-5 дугаар саруудад Д.Амарсанаа, 2022.06.28-ны өдрөөс эхлэн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтөр, 2 дугаар гарын үсгийг ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Алтанцэцэг нар зурж, нярвын бараа материалын тайланг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г.Сайханжаргал бэлтгэжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолын 2022.02.11-ний өдрийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр" батлах тухай 01 дүгээр тогтоол;
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 202203.07-ны өдрийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/43 дугаар тушаал;
- 2022.03.27-ны өдрийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай" А/54 дүгээр тушаал;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн 2022 онд хэрэгжүүлэх хяналт, шалгалтын төлөвлөгөөний 1.1.6-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтөд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” арга хэмжээг 2022 оны 9 дүгээр сард хэрэгжүүлэхээр заасан боловч удирдамж батлагдаагүйгээс тус арга хэмжээг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн ба дотоод аудитын хяналтыг цаашид сайжруулах шаардлагатай тул менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлж ажиллав.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 490,202.7 мянган төгрөгөөр буюу 131.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Хөтөлбөртэй холбоотой авлага	1,563,837.4	2,057,657.1	493,819.7
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,617.0	0	-3,617.0
Нийт хөрөнгө	1,567,454.4	2,057,657.1	490,202.7
Өр төлбөр	-	1,120.0	1,120.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,567,454.4	2,056,537.1	489,082.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,567,454.4	2,057,657.1	490,202.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 2. Хөтөлбөртэй холбоотой авлагын үзүүлэлт

№	Төсөл	/мянган төгрөгөөр/			
		Авлагын эхний үлдэгдэл	Тайланд онд олгосон санхүүгийн дэмжлэг	Төлсөн авлагын дүн	Авлагын эцсийн үлдэгдэл
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	598,313.7	500,000.0	182,609.0	915,704.7
2	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	196,001.0	-	44,465.0	151,536.0
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	525,635.8	195,000.0	102,443.0	618,192.8
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	146,311.1	72,000.0	32,409.8	185,901.4
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	64,050.0	125,000.0	23,875.0	165,175.0
6	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	33,525.8	-	21,530.6	11,995.2
7	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	-	10,000.0	848.0	9,152.0
ДҮН		1,563,837.4	902,000.0	408,180.3	2,057,657.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, харилцах дансны хуулга, мөнгөн хөрөнгийн журнал

Оны эхний хөтөлбөртэй холбоотой авлагын үлдэгдэл 1,563,837.4 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 408,180.3 мянган төгрөгийн авлага төлөгдөн, тайлант онд шинээр нэмж олгосон 902,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн авлага нэмэгдсэн байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 38 хүн хамрагдаж, 144,0000.0 мянган төгрөгийн зээл авч, гэрээний дагуу 50 хувийг буцаан төлөхөөр гэрээ хийж, авлагаар 72,000.0 мянган төгрөгийг бүртгэжээ.

Өмнөх оны эцэст төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлгийн 3,617.0 мянган төгрөгийн авлага 2022 оны 7 дугаар сард дансанд орж, тус авлага барагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 70,836.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,142,132.6 мянган төгрөг болсон байна.

Байгууллагын санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн санхүүгийн дэмжлэг Төрийн сан дахь 100030037010 тоот дансанд төвлөрдөг, тайлант онд тус дансанд нийт 669,162.2 мянган төгрөг орсон ба 408,180.3 мянган төгрөгийн хөтөлбөр санхүүжилтийн, 3,617.0 мянган төгрөгийн өмнөх оны авлага төвлөрч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулаагүйн төлбөрт 4 аж ахуйн нэгжээс 13,201.3 мянган төгрөг төвлөрч, төвлөрсөн орлогыг дээд шатны байгууллагын дансанд төвлөрүүлж, 11-12 дугаар сард данс андуурч 1,120.0 мянган төгрөг орсныг санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэж, үлдэгдлээр гарсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 489,082.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,057,657.1 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төслийг 2021.05.17-ны өдөр боловсруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг 3,500.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын санхүүжилтийг 936,421.7 мянга, нийт 939,921.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг 500.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын санхүүжилтийг 1,155,861.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан нь сангуудад олгох санхүүжилтийг өмнөх оноос нэмэгдүүлсэн, 2 хөтөлбөр шинээр хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

ХХҮЕГ-ын даргын 2022.03.22-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар Баянхонгор аймаг дахь ХЭДС-ийн 2022 оны төсвийн хуваарийг 2,096,283.0 мянган төгрөгөөр баталсныг 2022 оны 10 дугаар сард шинэчлэн баталж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх зардалд 8,000.0 мянган төгрөгийг нэмж баталж, нийт 2,104,283.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72102 (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих) хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгосон батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,997,153.9 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн батлагдсан төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна. Энэ нь дараах шалтгаантай байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд заасан 25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 хэсэгт тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор урамшууллыг тус бүр нэг удаа олгоно” гэсэн арга хэмжээ гараагүйгээс зардал 55,790.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 44,004.4 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн нь гэрээт малчин өрхийн гишүүний нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх зардалд 4,032.0 мянган төгрөг төлөвлөснийг олгоогүй, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн зардлыг 26,640.0 мянга, ажил олгогчийг дэмжих арга хэмжээний зардлыг 11,520.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс хүүхэд харах төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх зардал 3,919.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	65,640.0	65,640.0	-	100.0
2	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	907,762.0	863,757.6	44,004.4	95.2
3	ХБИ -ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	247,756.0	191,966.0	55,790.0	77.5
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	55,096.0	54,964.7	131.3	99.8
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	153,200.0	153,032.0	168.0	99.9
6	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	31,029.0	27,110.0	3,919.0	87.4
7	Ногоон ажлын байр хөтөлбөр	550,000.0	550,000.0	-	100.0
8	Ажилд зуучлах	24,000.0	23,990.4	9.6	100.0
9	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	12,600.0	12,588.0	12.0	99.9
ДҮН		2,047,083.0	1,943,048.7	104,034.3	95.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн тохируулгын дэлгэрэнгүй тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан улсын төсвөөс авах санхүүжилт нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон, улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 1,416,442.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,100,283.0 мянган төгрөг болсон ба батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, батлагдсан төсвийн 95.1 хувь буюу 1,997,153.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 103,129.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хуулийн дагуу суутган тооцсон хувь хүний орлогын албан татварыг НБББББ-т тусгасны дагуу өглөгөөр бүртгэх, бараа материалыг шаардах хуудсаар олгож, бараа материалын тайланг бүрэн гаргах, санхүүгийн дэмжлэгийн гэрээнд дэмжлэг эргэн төлөх хугацааг өдрөөр тусгах, шатахуун худалдан авсан и-баримт, зам явсан хуудсыг санхүүгийн тайланд бүрэн хавсаргах, төрийн аудитын байгууллагын өгсөн төлбөрийн актыг биелэлтийг үнэн зөв гаргаж ирүүлэх, ажил олгогчийн урамшуулал олгосон аж ахуйн нэгжүүдэд холбогдох чиглэл заавар өгч ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,100,283.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,504.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22,052.9 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд газраас ямар нэгэн шийдвэр ирээгүй, сангийн төсвийн менежер, ахлах мэргэжилтэн нар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: гар утасны зардал;” гэснийг зөрчиж, тайлант онд 510.0 мянган төгрөгийг гар утасны зардалд олгосон тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022.11.25-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 100,305.0 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 996,910.7 мянган төгрөгийн 36 зарлагын гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулах 221,159.5 мянган төгрөгийн 4 шийдвэр, сургалт, худалдан авагч байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, 282,392.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг нөхөн байршуулах 1 албан шаардлага өгч, менежментийн захидлаар 1 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	282,392.1	1	205,576.3	72.8
Албан шаардлага	1	0	1	0	50
Зөвлөмж	1	130,000.0	1	130,000.0	100
Нийт дүн	3	412,392.1	3	335,576.3	74.2

Төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийн биелэлтийг 2022.12.15-ны өдрийн 562 дугаартай албан бичгээр ирүүлэн, аудитаар тогтоосон төлбөрийн актаас 205,576.3 мянган төгрөгийн авлагыг сангийн дансанд төвлөрүүлж, 76,815.7 мянган төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн гэж ирүүлсэн байна.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн талаар тулгалт хийж, сангийн дансанд төвлөрсөн хугацаа хэтэрсэн авлагын төлөлтийг тулгахад зөрүүтэй, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил

илэрсэн байна. Төсвийн захирагч нас барсан тул шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулаагүй алдаанд зөвлөмж хүргүүлэн, аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үнэн зөв гаргаж байх зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 3.44-т “Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно” гэснийг мөрдөж ажиллаж, ажил олгогчийн урамшуулалд хамрагдсан иргэдийг мэдээллийг авч тулгалт хийх нь зүйтэй байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, авлагын барагдуулалт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулж, баталсан төлөвлөгөөний дагуу хяналтыг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн авлагын бүртгэлийн 3.2.2-т зээлийн эргэн төлөлтийг явцын хугацаа хэтэрсэн хоногоос хамаарч хэвийн, анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл гэж ангилж, хууль шүүхийн байгууллагад хүргүүлнэ гэснийг мөрдөж ажиллах шаардлагатай ба санхүүгийн дэмжлэг олгох гэрээнд зээлийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд алданги тооцох заалт хэрэгжихгүй байгааг анхаарч ажиллах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитаар нийт 521,439,6 мянган төгрөгийн 11 зөрчил¹ илэрснээс 346,682.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, орхигдуулсан мэдээллийг нөхөн байршуулах 1 албан шаардлага өгч, 174,757.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг үзүүлэх зээл авсан иргэд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс 140 иргэн 343,484.0 мянган төгрөгийн авлагыг хугацаанд нь төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байхад төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн авлагын бүртгэлийн 3.2.2-т зээлийн эргэн төлөлтийг явцын хугацаа хэтэрсэн хоногоос хамаарч хэвийн, анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл гэж ангилж, хууль шүүхийн байгууллагад хүргүүлнэ” заалт болон иргэдтэй байгуулсан санхүүгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дэмжлэг олгох гэрээний “Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу Б тал эргэн төлөлтийг хугацаанд нь төлөх үүрэгтэй” гэснийг зөрчсөн байна.

Шалгагдагч байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020.05.20-ны өдрийн 03 дугаар тогтоолыг ирүүлсэн, тус тогтоол нь аудитын хамрагдах хугацаанд хамаарахгүй тул ТАБ-аас саналыг хүлээн авах боломжгүй байгаа ба дээрх хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг 2023.07.30-ны дотор санд төлүүлэх төлбөрийн актыг тогтоов.

2. Албан хаагчдад гар утасны төлбөрт тайлант онд 510.0 мянган төгрөгийг олгож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал" гэснийг зөрчсөн тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зааврыг МУЕА-ын баталсан, аудитыг зааврын дагуу албан хаагчдаар 510.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

3. Байгууллагын 6 албан хаагч 2022.11.01-ээс авлага барагдуулах ажлаар хөдөө сумдад ажилласан томилолтын хуудсыг төсвийн захирагч олгохыг зөвшөөрч хаагаагүй, томилолтоор ажилласан илтгэх хуудасгүй байхад томилолтод 2,688.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь ХХҮГ-ын даргын 2022.04.06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 11.1 /Б/-т заасан “Томилолт дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас, холбогдох баримт бичгийг өгч томилолтын тайлан, үр дүнг газрын болон хэлтсийн дарга дүгнэж, томилолтын тооцоо хийх зөвшөөрлийг олгоно” гэснийг зөрчсөн тул томилолтын зардал олгосон албан хаагчдаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 100,305.0 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 996,910.7 мянган төгрөгийн 36 зарлагын гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулах 221,159.5 мянган төгрөгийн 4 шийдвэр, сургалт, худалдан авагч байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан 24 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн тул шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орхигдуулсан мэдээллийг хугацаанд нь нөхөн мэдээлэх, сангийн ахлах мэргэжилтний ажлын хариуцлагыг сайжруулах албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн ахлах мэргэжилтэн тайлант онд урамшуулал, ажлын хөлснөөс суутгасан 42,595.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг шууд зардлаар тайлагнаж өглөгөөр тусгаагүй, худалдан авсан 34,087.8 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар олгоогүй, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалт, ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.3 дахь бараа материалын бүртгэл, 3.4 дэх өр төлбөрийн бүртгэлийг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу нөхөн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, бараа материалын тайланг бүрэн гаргах

2. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зургаан сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй 19 иргэнийг ажлын байраар хангасан 10 ажил олгогчид 2022 онд нийт 95,760.0 мянган төгрөгийг олгосон ба аудитаар эдгээр 19 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгахад иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчид 2023 онд үргэлжлүүлэн төлөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж"-ийн 3.44-т "Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно" гэснийг мөрдөн, төсөл арга хэмжээний бодлого, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах, иргэдийн ажлын байраар хангах талаар ажил олгогчид шаардлагыг журмын дагуу тавьж, хяналтыг тогтмол хийж ажиллах

3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд олгосон шатахууны зардлаас 2,314.6 мянган төгрөгийн шатахууны и-баримт, зам явсан хуудсыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэл хөтлөлт, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, сангийн ахлах мэргэжилтэн ажлын хариуцлагаа дээшлүүлэх

4. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээнд Өлзийт сум зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хавсаргаагүй, Жинст, Богд, Баянбулаг, Жаргалант сумдын гэрээнд зээлийн эргэн төлөлтийг төлөх өдрийг бичээгүй, улирлаар гаргасан,

Жаргалант сумын мэргэжилтэн батлан даалтын гэрээнд гарын үсэг зураагүй, гэрээт малчин өрхийг малжуулах гэрээнд эргэн төлөлтийг өдрөөр гаргаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дэмжлэгийг олгох зээлийн гэрээний эргэн төлөлтийг улирлаар гаргаж байгааг зогсоон, төлөх хугацааг он, сар, өдрөөр гарган, гэрээг хууль, журмын дагуу хүчин төгөлдөр байгуулж, баталгаажуулах

5. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх албан шаардлагыг сангийн ахлах мэргэжилтэн бүрэн биелүүлээгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил тайлант онд давтагдан гарсан байна. /Тайлант онд төсвийн захирагч солигдсон тул төсвийн захирагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлээгүй болно/

Өгсөн зөвлөмж: Сангийн ахлах мэргэжилтний ажлын хариуцлагыг дээшлүүлж, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байгаад төсвийн захирагчаас тавих хяналтыг сайжруулах

6. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар тогтоосон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг иргэдээр нөхөн төлүүлэх төлбөрийн төлбөрийн актыг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд нь барагдуулаагүй, оны эцэст санд төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад зөрүүтэй тайлагнасан, аудитын явцад төлбөрийн актын биелэлтийг удаа дараа шаардуулж ирүүлсэн.

Өгсөн зөвлөмж: Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь “Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй: төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх”, 16.1.4 дэх “төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх” гэснийг мөрдөж, албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, арга хэмжээ авч ажиллан төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийн биелэлтийг үнэн зөв, хугацаанд нь тайлагнаж байх

7. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн 2022 онд хэрэгжүүлэх хяналт, шалгалтын төлөвлөгөөний 1.1.6-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтөд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” арга хэмжээг 2022 оны 9 дүгээр сард хэрэгжүүлэхээр заасан боловч удирдамж батлагдаагүйгээс тус арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хугацаа хэтэрсэн авлага нэмэгдсэн байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, гарсан үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авч, үр дүнг тооцож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс 140 иргэн 343,484.0 мянган төгрөгийн зээлийг хугацаа хэтрүүлсэн байхад төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	343,484.0	1	343,484.0									
Байгууллагын 6 албан хаагч 2022.11.01-ээс авлага барагдуулах ажлаар хөдөө сумдад ажилласан томилолтын хуудсыг төсвийн захирагч олгохыг зөвшөөрч хаагаагүй, томилолтоор ажилласан илтэх хуудасгүй байхад томилолтод 2,688.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	2,688.0	1	2,688.0									
Сангийн ахлах мэргэжилтэн тайлант онд урамшуулал, ажлын хөлснөөс суутгасан 42,595.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг шууд зардлаар тайлагнаж өглөгөөр тусгаагүй, худалдан авсан 34,087.8 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар олгоогүй, тайлан гаргаагүй байна.	1	76,683.0					1	76,683.0					
Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээнд Өлзийт сум зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хавсаргаагүй, Жинст, Богд, Баянбулаг, Жаргалант сумдын гэрээнд зээлийн эргэн төлөлтийг төлөх өдрийг бичээгүй, улирлаар гаргасан, Жаргалант сумын мэргэжилтэн батлан даалтын гэрээнд гарын үсэг зураагүй, гэрээт малчин өрхийг малжуулах гэрээнд эргэн төлөлтийг өдрөөр гаргаагүй байна.	1	0.0					1	0.0					

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх албан шаардлагыг сангийн ахлах мэргэжилтэн бүрэн биелүүлээгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байгуулаагүй зөрчил давтагдан гарсан байна.	1	0.0					1	0.0				
ТАБ-аас өмнөх аудитаар тогтоосон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг иргэдээр нөхөн төлүүлэх төлбөрийн төлбөрийн актыг ТАБ-аас тогтоосон хугацаанд нь барагдуулаагүй, оны эцэст санд төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад зөрүүтэй тайлагнасан, аудитын явцад төлбөрийн актын биелэлтийг удаа дараа шаардуулж ирүүлсэн.	1	0.0					1	0.0				
Зургаан сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй 19 иргэнийг ажлын байраар хангасан 10 ажил олгогчид 2022 онд нийт 95,760.0 мянган төгрөгийг олгосон ба аудитаар эдгээр 19 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгахад иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчид 2023 онд үргэлжлүүлэн төлөөгүй байна.	1	95760.0					1	95760.0				
Тайлант хугацаанд олгосон шатахууны зардлаас 2,314.6 мянган төгрөгийн шатахууны и-баримт, зам явсан хуудсыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй байна.	1	2314.6					1	2314.6				
Захиргаа, хяналтын хэлтсийн 2022 онд хэрэгжүүлэх хяналт, шалгалтын төлөвлөгөөний 1.1.6-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтөд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх" арга хэмжээг 2022 оны 9 дүгээр сард хэрэгжүүлэхээр заасан боловч удирдамж батлагдаагүйгээс тус арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хугацаа хэтэрсэн авлага нэмэгдсэн байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	0					1	0				
ДҮН	9	520,929.6	2	346,172.0	0	0	7	174,757.6	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 100,305.0 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 996,910.7 мянган төгрөгийн 36 зарлагын гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулах 221,159.5 мянган төгрөгийн 4 шийдвэр, сургалт, худалдан авагч байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан 24 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	0			1	0		0
Дүн	1	0	0	0	1	0	0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Албан хаагчдад гар утасны төлбөрт тайлант онд 510.0 мянган төгрөгийг олгож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал" гэснийг зөрчсөн байна.	1	510.0	1	510.0				
Дүн	1	510.0	1	510.0	0	0	0	0
Нийт дүн	2	510	1	510.0	1	0	0	0

---oOo---